

**БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГЫГ ЧӨЛӨӨЛӨХ, СОНГОХ ТАЛААР
ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНООС ГАРГАСАН САНАЛ, ДҮГНЭЛТ**

2014 оны 12 дугаар
сарын 24-ний өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Н.Батбаяр

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт заасныг үндэслэн Байнгын хорооны даргыг чөлөөлөх, сонгох тухай асуудлыг Төсвийн байнгын хороо 2014 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн 2015 оны төсвийн тодотголыг Байнгын хороогоор хэлэлцэх ажлыг удирдан зохион байгуулах боломжгүй гэсэн өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөх өргөдөл гаргасныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжлээ.

Улсын Их Хурлын гишүүн Н.Батбаяр Төсвийн байнгын хорооны даргад Улсын Их Хурлын гишүүн Б.Болорыг нэр дэвшүүлсэн болно.

Б.Болор нь 1994 онд НАТО-ийн дэргэдэх бүрэн дунд сургуулийг, 1997 онд Бельгийн Вант улсын Европын их сургуулийг, 2012 онд Шинжлэх ухаан технологийн их сургуулийг төгссөн. Эдийн засагч мэргэжилтэй, Эдийн засгийн ухааны магистрийн зэрэгтэй. Орос, Англи, Франц хэлтэй. 1997-2000 онд Төрийн өмчit “НИК” ХК-ийн гадаад харилцааны газарт мэргэжилтэн, 2000-2006 онд Гарьд-тур ХХК-ийн ерөнхий захирал, Тиара-Монголия төслийн удирдагч, 2008-2012 онд Гадаад харилцааны дэд сайд, 2012 оноос Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдон ажиллаж байна.

Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудлыг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн Төсвийн байнгын хорооны даргад Улсын Их Хурлаас байгуулагдсан Улсын төсвийн тухай хуулийн төслийн ажлын хэсгийн ахлагчаар сүүлийн 3 жил амжилттай ажиллаж, туршлага хуримтлуулсан, цаашид тус Байнгын хороог удирдах чадвартай хүнийг нэр дэвшүүлж байгаа тул дэмжих нь зүйтэй гэсэн саналыг гаргасан болно.


Төсвийн байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Б.Болорыг сонгох нь зүйтэй гэсэн саналыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүд санал нэгтэй дэмжлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Байнгын хорооны даргыг чөлөөлөх, сонгох талаар Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**



Ц.ДАВААСҮРЭН